

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2009 оны 10 дугаар  
сарын 28-ны өдөр

№ 255

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн цахим мөнгөний  
үйлчилгээний түр журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний түр журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## БАНК БУС САНХҮҮГИЙН ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТҮР ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6-д заасан цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааны дагуу банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээ эрхлэхэд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс сэргийлэх, цахим мөнгөний үйлчилгээний хэлбэрийг оновчтой тодорхойлох, боловсронгуй болгох, оролцогч талуудын нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ноос Банк бус санхүүгийн байгууллагын эрхлэх тус үйлчилгээг зохицуулах, хяналт тавихад оршино.

1.2. Төлбөр тооцоог цахим мөнгө ашиглан гүйцэтгэх техник, технологийн шаардлага хангасан, Хорооноос банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан Банк бус санхүүгийн байгууллага эрхэлнэ.

1.3. ББСБ нь банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээ эрхлэхдээ Монгол Улсын холбогдох хууль болон тэдгээртэй нийцүүлэн Хорооноос баталсан журам, шийдвэрийг удирдлага болгоно.

### ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч” гэж Хорооноос цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ-ыг;

2.1.2. “Төлөөлөгч” гэж цахим мөнгөний үйлчилгээг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тухайн нутаг дэвсгэрт хүргэх, цахим хэтэвч эзэмшигчдийн бүртгэл болон бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээг гүйцэтгэх иргэн, хуулийн этгээдийг;

2.1.3. “Гэрээт хамтрагч” гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж, өөрийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг цахим хэтэвч эзэмшигчдэд цахим мөнгөөр борлуулах хүсэлтэй иргэн, хуулийн этгээдийг;

2.1.4. “Цахим хэтэвч эзэмшигч” гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн цахим мөнгөний үйлчилгээг гар утас болон интернэт ашиглан, түүний үйлчилгээг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

2.1.5. “Цахим мөнгөний үйлчилгээ” гэж цахим хэтэвч эзэмшигчийн бэлэн мөнгийг цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглан цахим мөнгөн хэлбэрт хөрвүүлэх, буцаан хөрвүүлэх, түүний хүсэлтээр мөнгөн шилжүүлэг, төлбөр тооцоог түргэн шуурхай, баталгаатай гүйцэтгэх үйл ажиллагааг;

2.1.6. “ПОС терминал” гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс цахим мөнгөний төлбөр тооцоог гүйцэтгэх зорилгоор төлөөлөгч, гэрээт хамтрагчийн үйлчилгээний цэгүүдэд суурилуулсан, цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжийг хэлнэ.

2.1.7. “Цахим мөнгө” гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс нэхэмжилж болохуйц, төлбөр тооцоонд ашиглагдах бүрэн боломжтой, мөнгөний үнэ цэнтэй зүйлийг хэлнэ.

Цахим мөнгө нь дараахь шинж тэмдэгийг агуулна. Үүнд:

2.1.7.1. Тусгай зориулалтын цахим төхөөрөмжид байрлах боломжтой;

2.1.7.2. Цахим хэтэвч эзэмшигчийн бэлэн мөнгийг мөнгөн дүнтэй нь тэнцэх хэмжээний цахим мөнгөнд, шаардлагатай тохиолдолд бэлэн мөнгөнд буцаан хөрвүүлэх боломжтой;

2.1.7.3. Цахим мөнгө нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн нэрлэсэн үнээр илэрхийлэгдэх бөгөөд мөнгөн хадгаламж гэж үзэхгүй, түүнд хүү, урамшуулал бодогдохгүй.

#### ГУРАВ. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн дүрмийн сангийн доод хэмжээг Хороо тогтооно.

3.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цахим мөнгөний үйлчилгээг зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэнэ.

3.3. Цахим мөнгөний үйлчилгээ нь бусдаас ялгарах өөрийн гэсэн оноосон нэртэй байна.

3.4. Цахим хэтэвч эзэмшигчийг эрсдэлээс хамгаалах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь өөрийн хөрөнгийн 50 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний бэлэн мөнгийг цахим мөнгөнд хөрвүүлнэ.

3.5. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нийт цахим мөнгөний 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний түргэн хөрвөх чадвар бүхий хөрөнгөтэй байна. Энэ хөрөнгө нь бусад хэлбэрээр зарцуулагдахгүй ба дараах хэлбэртэй байна:

3.5.1. Банкинд байршуулсан хадгаламж;

3.5.2. Засгийн газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт;

3.6. Цахим хэтэвч эзэмшигчийн нэг удаад хийх гүйлгээний дээд хэмжээ 100,000.00 /нэг зуун мянга/ төгрөг, нэг өдөрт хийх гүйлгээний дээд хязгаар 500,000.00 /таван зуун мянга/ төгрөг байна.

3.7. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь Хорооноос батлагдсан үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана.

3.8. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн шийдвэр гаргах гүйцэтгэх удирдлагад мэдээллийн технологийн боловсролтой, туршлагатай боловсон хүчин ажиллана.

3.9. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь цахим хэтэвч эзэмшигчийн холбогдох мэдээлэл, нэгж дансны болон нэгтгэсэн балансад шаардагдах нарийвчилсан, бүрэн мэдээллийг агуулах, хөтлөх боломж бүхий мэдээллийн системтэй байна. Тус систем нь цахим мөнгөний хөдөлгөөнийг хянах, цахим хэтэвч эзэмшигчид болон цахим мөнгөний тоо хэмжээг тогтоох чадвартай байна. Санаандгүй хийгдсэн буруу гүйлгээ, мэдээллийг уг системийн зүгээс олж тогтоох чадвартай байна.

3.10. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээний журам, эрх, үүрэг, хариуцлагын талаар цахим хэтэвч эзэмшигч, гэрээт хамтрагч бүрт танилцуулан хамтран ажиллах гэрээг бичгээр үйлдэх бөгөөд үйлчилгээтэй хамааралтай үүсэх бүх хариуцлагыг хүлээнэ.

3.11. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь харилцагчийн гомдол, саналыг барагдуулах тохиромжтой тогтолцоо бий болгож ажиллана.

3.12. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь цахим мөнгөний тогтолцоонд ямар нэгэн өөрчлөлт хийхээс 30 хоногийн өмнө энэ талаар Хороонд мэдэгдсэн байна. Цахим тоног төхөөрөмжийн үзүүлэх үйлчилгээний цар хүрээг тэлэх, эсвэл тухайн хэрэгслийн мөн чанарыг өөрчлөхөөр бол Хорооны зөвшөөрлөөр шийдвэрлэнэ. Эдгээр өөрчлөлт, шинэчлэлт нь дараах хэлбэртэй байж болно:

3.12.1. Шинэ сувгуудыг ашиглан цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний цар хүрээг тэлэх /интернет хандалт, ПОС терминал гэх мэт/

3.12.2. Технологийг бэлтгэн нийлүүлэгч болон гол гэрээт хамтрагч байгууллагууд өөрчлөгдсөн;

3.12.3. Бусад өөрчлөлт.

3.13. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн хяналтын систем дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.13.1. Үйл ажиллагааны болон техник, технологийн горим, шаардлагыг хангасан дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлсэн;

3.13.2. Техник, технологийн систем нь хэрэглээнд гарахаасаа өмнө бүрэн туршигдаж, өөрийн зогсолтгүй үйл ажиллагааг хангах бүрэн боломжтой;

3.13.3. Өгөгдлийн болон өгөгдөл боловсруулагч системийн аюулгүй, зохистой, бүрэн ажиллагааг хангасан мэдээллийн технологийн дотоод горим хяналттай;

3.13.4. Үйл ажиллагааг доголдолгүй хангах, аливаа гамшгаас сэргийлэх, эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөтэй;

3.14. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь өөрийн төлөөлөгч, гэрээт хамтрагчийн өмнөөс Хорооны өмнө хариуцлага хүлээнэ.

## ДӨРӨВ. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь дараах эрх, үүргийг хүлээнэ:

4.1.1. Үйл ажиллагаандаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай болон бусад холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр байнга хяналт тавьж ажиллах;

4.1.2. Цахим хэтэвч эзэмшигч, төлөөлөгч, гэрээт хамтрагчтай байгуулах гэрээг Иргэний хууль болон энэхүү журмын дагуу хүчин төгөлдөр шийдвэрлэх, гэрээнд цуцлах нөхцөл, үйлчилгээний журам, хариуцлагын талаар тодорхой тусгах;

4.1.3. Цахим хэтэвч эзэмшигч, төлөөлөгч, гэрээт хамтрагчийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөх, тэдгээрийн санал, гомдлыг ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэх зэрэг хяналтын тогтолцоо бий болгох;

4.1.4. Санхүүгийн тайлан, цахим хэтэвч эзэмшигч, төлөөлөгч, гэрээт хамтрагч, тэдгээрийн байршлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим мөнгөний мэдээ зэргийг энэ журмын 1, 2, 3 дугаар хавсралтын дагуу гаргаж, сар бүрийн эхний 7 хоногийн дотор Хороонд шинэчлэн ирүүлж байх;

4.1.5. Хорооноос шаардсан мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх, Хорооны хянан шалгагч, шалгалтын ажлын хэсгийг шалгалтын удирдамжийн дагуу ажлын байр болон мэдээллийн баазад чөлөөтэй нэвтрүүлэх;

4.1.6. Ажил, үйлчилгээ, гүйлгээгээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, Хорооны “Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар”-г заасны дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгах;

4.1.7. Цахим хэтэвч эзэмшигч, төлөөлөгч, гэрээт хамтрагчийг сургах, мэдээлэл өгөх системийг бүрдүүлэх;

4.1.8. Цахим хэтэвч эзэмшигч бусдад санаатай хохирол учруулахаар завдсанаас бусад тохиолдолд энэ журмын 4.3.2-т заасан үүргийг биелүүлснээс хойш учирсан хохирлыг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч хариуцна.

4.1.9. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь өөрийн хяналтын системийн доголдолгүй ажиллагааг өөрөө хариуцна.

4.2. Цахим хэтэвч эзэмшигч нь дараах эрхтэй байна:

4.2.1. Гэрээний үндсэн дээр цахим мөнгөний үйлчилгээнд оролцох;

4.2.2. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн дүрэм, үйл ажиллагааны журамтай танилцах, өөрт холбогдох дансны хуулга болон мэдээллийг гаргуулах;

4.3. Цахим хэтэвч эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ:

4.3.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид өөрт холбогдолтой үнэн, зөв мэдээллийг бүрэн өгөх;

4.3.2. Цахим хэтэвч эзэмшигч нь нууц кодоо үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн дансанд эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн тухай мэдсэн, өөрийн данстай холбоотой бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн болон өөрийн нууц код болон бусад

кодыг эрх олгогдоогүй гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй тухай сэжиглэж байвал нэн даруй цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх;

4.3.3. Энэ журмын 4.3.2-т заасан үүргийг биелүүлээгүйн улмаас үүссэн хохирлыг цахим хэтэвч эзэмшигч хариуцна.

4.3.4. Цахим хэтэвч эзэмшигч нь дансны нууц код болон бусад мэдээллийн нууцлалыг хадгалах;

4.4. Гэрээт хамтрагч нь дараах үүргийг хүлээнэ:

4.4.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй хийсэн гэрээний үндсэн дээр цахим хэтэвч эзэмшигчийн төлбөрийг түргэн шуурхай, үнэн зөв хүлээн авах үйлчилгээг тогтмол гүйцэтгэх;

4.4.2. Цахим хэтэвч эзэмшигчийн гомдол, саналыг хүлээн авч цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх, шийдвэрлэх;

4.4.3. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй сарын дотор тооцоо нийлж, баримтаар баталгаажуулах;

4.5. Төлөөлөгч нь дараах үүргийг хүлээнэ:

4.5.1. Цахим хэтэвч эзэмшигчийн бүртгэлийг үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэх;

4.5.2. Цахим хэтэвч эзэмшигчийн хүсэлтээр бэлэн мөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэх, цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх;

4.5.3. Цахим хэтэвч эзэмшигчийн гомдол, саналыг хүлээн авч цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх, шийдвэрлэх;

4.5.4. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй сарын дотор тооцоо нийлж, баримтаар баталгаажуулах;

4.6. Төлөөлөгч нь дараах эрхийг эдэлнэ:

4.6.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр санхүүгийн гүйлгээ хийсний шимтгэл авах;

## ТАВ. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

5.1. Цахим төлбөрийн хэрэгсэлд байршуулсан мөнгөн хөрөнгийг цахим хэтэвч эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр гүйлгээнд оруулах;

5.2. Цахим мөнгийг нэрлэсэн үнээс хямдруулах болон нэмэгдүүлэх;

5.3. Цахим хэтэвч эзэмшигч, төлөөлөгч, гэрээт хамтрагчийн нууцийг задруулах;

## ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд санхүү, төлбөрийн эрсдэл үүсэх магадлалтай болсон нөхцөлд Хорооноос дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

6.1.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага тавих;

6.1.2. Бэлэн мөнгийг цахим мөнгөнд нэмж хөрвүүлэхийг хориглох;

6.2. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь энэ журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээхээргүй бол хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл ногдуулах болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

*“Цахим мөнгөний үйлчилгээний түр  
журам”-ын 1 дүгээр хавсралт*

..... ББСБ ХХК-ИЙН ГЭРЭЭТ ХАМТРАГЧИЙН БҮРТГЭЛ<sup>1</sup>

20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн байдлаар

№	Гэрээт хамтрагчийн нэр	Гэрээний дугаар	Гэрээ байгуулсан огноо	Этгээдийн		Хаяг	Гүйцэтгэх удирдлагын		Тайлбар*
				Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар/Иргэний үнэмлэхний дугаар		Овог нэр	Утас	

<sup>1</sup> Урьд мэдээнд тайлагнасан гэрээт хамтрагч хасагдаагүй тохиолдолд дахин тайлагнах шаардлагагүй

\* Шинээр нэмэгдсэн эсвэл хасагдсан гэрээт хамтрагчийн талаарх дэлгэрэнгүй тайлбар

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: ..... /Овог, нэр/      *тамга*

НЯГТЛАН БОДОГЧ: ..... /Овог, нэр/



“Цахим мөнгөний үйлчилгээний түр  
журам”-ын 2 дугаар хавсралт

..... ББСБ ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ<sup>1</sup>

20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн байдлаар

№	Төлөөлөгчийн нэр	Гэрээний дугаар	Гэрээ байгуулсан огноо	Этгээдийн		Хаяг	Гүйцэтгэх удирдлагын		Тайлбар*
				Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар/Иргэний үнэмлэхний дугаар		Овог нэр	Утас	

<sup>1</sup> Урьд мэдээнд тайлагнасан гэрээг хамтрагч хасагдаагүй тохиолдолд дахин тайлагнах шаардлагагүй

\* Шинээр нэмэгдсэн эсвэл хасагдсан төлөөлөгчийн талаарх дэлгэрэнгүй тайлбар

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: ..... /Овог, нэр/ *тамга*

НЯГТЛАН БОДОГЧ: ..... /Овог, нэр/

20\_\_оны\_\_сарын\_\_өдөр

“Цахим мөнгөний үйлчилгээний түр  
журам”-ын 3 дугаар хавсралт

..... ББСБ ХХК-ИЙН ЦАХИМ МӨНГӨНИЙ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн байдлаар

№	Цахим хэтгэвч эзэмшигчдийн тоо	Хөрвүүлсэн мөнгөний дүн					Цахим мөнгөний үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгө	Түргэн хөрвөх хөрөнгийн дүн	Үүнээс	
		Цахим мөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний тоо	Цахим мөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний дүн /төгрөгөөр/	Бэлэн мөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний тоо	Бэлэн мөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний дүн /төгрөгөөр/	Цахим мөнгөний нийт гүйлгээний тоо /өссөн дүнгээр/				Цахим мөнгөний нийт гүйлгээний дүн /өссөн дүнгээр/ /төгрөгөөр/	Банкинд байршуулсан хадгаламж

тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: ..... /Овог, нэр/

НЯГТЛАН БОДОГЧ: ..... /Овог, нэр/

20\_\_оны\_\_сарын\_\_өдөр